*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 64,357.9 мянган төгрөгөөр өсөхөд ковидтой холбоотой эм боох материал, хүнсний материал, аж ахуйн материалын өсөлт голлох нөлөө үзүүлсэн ба бараа материалын үлдэгдэлд хийсэн шинжилгээнээс харахад сумын ЭМТ-ийн 66.0 мянган төгрөгийн сэлбэг, 1,026.5 мянган төгрөгийн барилгын засварын материал, 4,822.5 мянган төгрөгийн мал амьтад шилжилт хөдөлгөөн хийгдээгүй ба сумын ЗДТГ-т бүртгэлтэй 990.0 мянган төгрөгийн мал амьтад нь сайн үүлдрийн мал байна.

Харин Сумын ЭМТ-д бүртгэлтэй 3,832.5 мянган төгрөгийн мал амьтдын насжилтийг хийгээгүй шалтгааныг байгууллагын нягтлан бодогчоос тодруулахад бүртгэлээр байгаа боловч биетээр байхгүй гэсэн тайлбарыг өгсөн тул дараагийн аудитаар тодруулах шаардлагатай байна.

*Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | ИТХурал | ЗДТГазар | Сургууль | Цэцэрлэг | Соёл | ЭМТөв | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 6,746.73 | 61,774.5 | 97,124.70 | 65,952.07 | 7,264.33 | 82,898.04 | 321,760.31 |
| Нэмэгдсэн | 5,054.40 | 58,821.42 | 51,688.80 | 32,782.75 | 5,384.99 | 248,455.49 | 402,187.85 |
| Худалдан авсан | 5,054.40 | 46,791.92 | 51,350.80 | 32,568.75 | 5,384.99 | 231,624.28 | 372,775.15 |
| Шилжүүлэн авсан | - | 12,029.50 | 338.00 | 214.00 | - | 16,831.20 | - |
| Хандиваар ирсэн | - | - | - | - | - | 0.00 | - |
| Хасагдсан | 5,057.18 | 48,609.21 | 33,940.80 | 29,467.11 | 3,600.39 | 217,155.23 | 337,829.93 |
| Худалдсан, зарцуулсан | 5,057.18 | 48,109.21 | 33,940.80 | 19,636.59 | 3,600.39 | 217,155.23 | 327,499.41 |
| Шилжүүлсэн | - | 500.00 | - | - | - | 0.00 | - |
| Бусад | 0.00 | 0.00 | - | 9,830.52 | 0 | 0 | 9,830.52 |
| Эцсийн үлдэгдэл | 6,744.0 | 71,986.7 | 114,872.7 | 69,267.7 | 9,048.9 | 114,198.3 | 386,118.2 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,851,081.8 мянга, эцсийн үлдэгдэл 8,608,077.6 мянган төгрөг болж, 1,756,995.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба үндсэн хөрөнгийн өсөлт нь сумын Соёлын төвийн барилгыг хөрөнгөд орлогод авсантай холбоотой байна.

*Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 5,697,101.1 | 7,430,364.4 | 1,733,263.3 |
| Тээврийн хэрэгсэл | 223,439.2 | 179,702.8 | (43,736.4) |
| Машин тоног төхөөрөмж | 556,500.0 | 631,984.5 | 75,484.5 |
| Тавилга эд хогшил | 263,723.8 | 255,708.2 | (8,015.6) |
| Номын фонд | 18,024.2 | 18,024.2 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 3,000.0 | 3,000.0 | - |
| Программ хангамж | 1,735.5 | 1,735.5 | - |
| Бусад биет бус хөрөнгө | 87,558.0 | 87,558.0 | - |
| **Дүн** | **6,851,081.8** | **8,608,077.6** | **1,756,995.8** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 50,278.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 53,229.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, 1,733,263.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авчээ. Холбогдох байгууллагуудын шийдвэрээр тайлант онд 42,538.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

*Хүснэгт 7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | ИТХурал | ЗДТГазар | Сургууль | Цэцэрлэг | Соёл | ЭМТөв | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 13,089.0 | 2,985,093.9 | 1,880,815.4 | 1,047,481.4 | 391,932.9 | 532,669.2 | 6,851,081.8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэмэгдсэн | 0.0 | 22,011.0 | 19,609.7 | 8,820.8 | 1,740,506.8 | 45,822.5 | 1,836,770.8 |
| Худалдан авсан | 0.0 | 13,974.0 | 19,609.7 | 8,820.8 | 160.0 | 7,713.5 | 50,278.0 |
| Шилжүүлэн авсан | 0.0 | 8,037.0 | 0.0 | 0.0 | 7,083.5 | 38,109.0 | 53,229.5 |
| Бусад | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 1,733,263.3 | 0.0 | 1,733,263.3 |
| Хасагдсан | 7,500.0 | 14,000.0 | 0.0 | 16,629.2 | 11,909.4 | 29,736.4 | 79,775.0 |
| Акталсан | 0.0 | 14,000.0 | 0.0 | 16,629.2 | 11,909.4 | 0.0 | 42,538.6 |
| Шилжүүлсэн | 7,500.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 29,736.4 | 37,236.4 |
| Эцсийн үлдэгдэл | 5,589.0 | 2,993,105.0 | 1,900,425.1 | 1,039,673.0 | 2,120,530.4 | 548,755.2 | 8,608,077.6 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 25,843.7 мянга, эцсийн үлдэгдэл 3,485.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 22,358.1 мянган төгрөгөөр буурсан байна. Сумын ерөнхий боловсролын сургууль өмнөх оны 7,762.4 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж ажиллаж, оны эцэст өглөггүй ажилласан бол бусад төсөвт байгууллагууд оны эцэст өглөгтэй гарсан ба нийт өглөгийн 46.1 хувийг ЭМТ-ийн, 36.1 хувийг цэцэрлэгийн, 10.5 хувийг ЗДТГ-ын, 5.9 хувийг ИТХ-ын, 1.4 хувийг Соёлын төвийн өглөг эзэлж байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Үүнээс: | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ажиллагсадтай холбоотой | Байгууллагад төлөх өглөг | Бараа үйлчилгээний зардлын өглөг |
| 1 | ЗДТГ | 166.85 | 364.7 | 0.0 | 364.73 | 0.0 |
| 2 | ИТХ | 11.0 | 204.9 | 0.0 | 204.88 | 0.0 |
| 3 | ЕБС | 7,762.40 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 4 | Цэцэрлэг | 2,074.17 | 1,259ы.1 | 1,259.15 | 0.00 | 0.0 |
| 5 | ЭМТ | 15,569.39 | 1,606.5 | 0.0 | 0.0 | 1,606.51 |
| 6 | Соёлын төв | 259.95 | 50.4 | 0.00 | 50.38 | 0.0 |
| | **ДҮН** | 25,843.7 | 3,485.6 | 1,259.1 | 620.0 | 1,606.5 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,170,647.3 мянга, эцсийн үлдэгдэл 8,129,505.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,958,858.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,588,966.5 | 1,588,966.5 | - | 19.5 |
| Хуримтлагдсан үр дүн | 2,417,465.6 | 4,382,241.4 | 1,964,775.8 | 53.9 |
| Өмнөх үеийн үр дүн | 2,226,421.9 | 2,423,383.1 | 196,961.2 | |
| Тайлант үеийн үр дүн | 191,043.7 | 1,958,858.3 | 1,767,814.6 | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,164,215.2 | 2,158,297.7 | (5,917.5) | 26.5 |
| Дүн | 6,170,647.3 | 8,129,505.6 | 1,958,858.3 | 100 |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 1,958,858.3 мянган төгрөгөөр өссөн нь сумын Соёлын төвийн барилгыг үнэ төлбөргүй авснаас шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор Эрдэнэцогт сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 3,580.0 мянга, аймгийн төсөвт 105,120.0 мянга, нийт 108,700.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 128.8 хувиар биелүүлснээс улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг 560.5 мянга, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 30,728.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **А. Улсын төсөв** | **3,580.0** | **4,140.5** | **560.5** | **115.7** |
| 1. ААНБ-ын орлогын татвар | 1,000.0 | 1,216.5 | 216.5 | 121.7 |
| 2. Нэмэгдсэн өртгийн албан татвар | 600.0 | 60.0 | (540.0) | 10.0 |
| 3. Агаарын бохирдол /авто/ | 1,980.0 | 2,864.0 | 884.0 | 144.6 |
| **В.Аймгийн төсөв /712/** | **105,120.0** | **135,848.1** | **30,728.1** | **129.2** |
| 1. ЦТХА орлого /Суутган -1/ | 82,000.0 | 107,929.5 | 25,929.5 | 131.6 |
| 2. АТӨЯХ-ийн татвар | 18,000.0 | 23,910.7 | 5,910.7 | 132.8 |
| 3. ҮХЭХ-ийн татвар | 2,600.0 | 2,835.6 | 235.6 | 109.1 |
| 4. Газрын төлбөр | 2,520.0 | 1,172.3 | (1,347.7) | 46.5 |
| **Нийт дүн** | **108,700.0** | **139,988.6** | **31,288.6** | **128.8** |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ*

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл нэмэгдсэн өртгийн албан татвар, газрын төлбөрөөс бусад орлогыг 10.0-144.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 58,180.0 мянга, хүү торгуулийн орлогыг 2,000.0 мянга, нийт 60,180.0 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 11. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 1.Татварын орлого | **58,180.0** | **166,061.4** | **107,881.4** | **285.4** |
| 1.1.ИОТХ | 12,000.0 | 12,288.5 | 288.5 | **102.4** |
| 1.2. Хадгаламжийн хүүгийн орлого | 22,000.0 | 23,916.3 | 1,916.3 | **108.7** |
| 1.3. ҮХЭХ борлуулсны татвар | 3,000.0 | 881.0 | (2,119.0) | **29.4** |
| 1.3. Бууны татвар | 4,000.0 | 4,002.0 | 2.0 | **100.1** |
| 1.4.Улсын тэмдэгтийн хураамж | 1,500.0 | 1,286.5 | (213.5) | **85.8** |
| 1.5.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 6,000.0 | 5,338.9 | (661.1) | **89.0** |
| Түгээмэл тархацтай АМНАТ | 8,000.0 | 5,559.1 | (2,440.9) | **69.5** |
| 1.7.Газрын төлбөр | 1,680.0 | 785.2 | (894.8) | **46.7** |
| 1.8. Ургамал ашигласны төлбөр | | 2,794.3 | 2,794.3 | **#DIV/0!** |
| 1.9. Агнуурын нөөц ашигласны төлбөр | | 109,209.6 | 109,209.6 | **#DIV/0!** |
| 2.Татварын бус орлого | **2,000.0** | **4,380.0** | **2,380.0** | **219.0** |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 2,000.0 | 4,380.0 | 2,380.0 | **219.0** |
| **Нийт дүн** | **60,180.0** | **170,441.4** | **110,261.4** | **283.2** |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ*

Тайлант онд сумын төсөвт төвлөрөх татварын орлого 283.2 хувиар биелэхэд АСЕМГҮЛ САМАТ" ХХК-аас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу шонхор шувууны төлбөрт 3 удаагийн шилжүүлгээр 109,209.6 мянган төгрөгийг орсон нь голлох нөлөө үзүүлсэн ба харин сумын татварын орлогыг зөв төлөвлөөгүйгээс ҮХЭХ борлуулсны татвар, газрын төлбөр тасарсан байна.

Сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч орлого оруулаагүй байна.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 65,200.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 69,007.7 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 105.84 хувиар биелүүлсэн байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2,492,726.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,330,050.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2,285,621.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 44,429.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

## 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор нийт 2,498,987.6 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт 12.Төсөвт байгууллагуудын төсвийн төсөл, анхны төсвийн төсөл /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 103,354.40 | 78,611.50 | (24,742.90) |
| Засаг даргын Тамгын газар | 426,831.60 | 415,557.40 | (11,274.20) |
| Эрүүл мэндийн төв | 496,451.80 | 512,967.20 | 16,515.40 |
| Ерөнхий боловсролын сургууль | 888,043.90 | 780,094.10 | (107,949.80) |
| Цэцэрлэг | 334,920.50 | 350,712.10 | 15,791.60 |
| Соёлын төв | 226,972.70 | 171,164.20 | (55,808.50) |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 94,681.10 | 94,681.10 |
| Сум хөгжүүлэх сан | | 95,200.00 | 95,200.00 |
| **Нийт дүн** | 2,476,574.90 | 2,498,987.60 | 22,412.70 |

*Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, сумын ИТХ-ын 2/12 дугаар тогтоол*

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор анх баталсан 2,498,987,6 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2021.07.23-ны өдрийн 3/02 дугаар тогтоолоор төсвийг 18,739.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,517,726.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Сумын ЕБС, Цэцэрлэгийн төсвийг аймгийн Засаг даргын 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 25,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,492,726.6 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,396,902.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 42,560.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох

санхүүжилтээс, 74,681.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 882,382.7 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 66,200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 30,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, ОНХНС-ийн урамшууллыг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 23,864.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 3,807.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, оны эцэст зардлын хэмнэлтээс 55,806.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 13,752.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

*Хүснэгт 13.Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН-ын төсөвт төвлөрүүлсэн | Улсын төсөвт төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 464,452.0 | 433,247.4 | 31,204.6 | 93.28 | 30,204.6 | - |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 78,611.5 | 78,105.5 | 506.0 | 99.36 | 506.0 | - |
| Ерөнхий боловсролын сургууль | 793,996.7 | 787,690.8 | 6,305.9 | 99.21 | 1,814.6 | 4,491.4 |
| Цэцэрлэг | 291,057.1 | 278,023.1 | 13,034.0 | 95.52 | 3,814.4 | 9,219.6 |
| Эрүүл мэндийн төв | 525,330.7 | 484,335.7 | 40,995.0 | 92.2 | 17,088.6 | 41.5 |
| Соёлын төв | 169,397.5 | 167,018.8 | 2,378.7 | 98.6 | 2,378.7 | - |
| Орон нутгийн хөгжлийн сан | 74,681.1 | 44,429.2 | 30,251.9 | 59.49 | - | - |
| Сум хөгжүүлэх сан | 95,200.0 | 57,200.0 | 38,000.0 | 60.08 | - | - |
| **Нийт дүн** | **2,492,726.6** | **2,330,050.5** | **162,676.1** | **93.47** | **55,806.9** | **13,752.4** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,330,050.5 мянган төгрөг буюу 93.47 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, тогтмол зардал, хөрөнгийн зардлыг хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 413,607.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 282,659.7 мянган төгрөг зарцуулж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 78,785.1 мянга, албан хаагчдад 3,789.5 мянга, сумын ЭМТ-ийн албан хаагчдад 34,600.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгож, 7,713.5 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч, оны эцэст хэмнэлтийн 6,060.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ЗДТГ | ИТХ | ЕБС | Цэцэрлэг | Эрүүл мэндийн төв | Соёлын төв | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | **18,374.1** | **1,000.0** | **57,738.0** | **3,789.5** | **332,148.8** | **557.5** | **413,607.9** |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,718.59 | - | - | - | - | - | 2,718.6 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,209.87 | 1,000.00 | 37,550.08 | 3,789.53 | 82,284.06 | - | 128,833.5 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,445.68 | - | 20,187.91 | - | 4,906.20 | 557.50 | 37,097.3 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | - | - | - | - | 244,958.50 | - | 244,958.5 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **14,612.1** | **1,000.0** | **55,486.8** | **3,789.5** | **332,129.5** | **530.0** | **407,547.9** |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 14,612.06 | 1,000.00 | 24,385.73 | - | 242,131.98 | 530.00 | 282,659.8 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | - | - | 3,789.53 | - | - | 3,789.5 |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | - | - | - | 7,713.5 | - | 7,713.5 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | - | - | 34,600.0 | - | 34,600.0 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | - | - | - | - | - |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | 31,101.05 | - | 47,684.1 | - | 78,785.1 |
| **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг** | **3,762.08** | **0.00** | **2,251.21** | **0.00** | **19.22** | **27.50** | **6,060.01** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 141 мэдээллээс 89 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 52 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгснөөс шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4

байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамрагдсан байна.

*Хүснэгт 15. Аудитын хэлбэр, өгсөн санал дүгнэлт*

| № | Байгууллагын нэр | Аудит хийсэн байгууллагын нэр | Дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|
| 1 | Засаг даргын Тамгын газар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Хязгаарлалттай |
| 2 | Ерөнхий боловсролын сургууль | | Зөрчилгүй |
| 3 | Эрүүл мэндийн төв | "Глобал капитал аудит" ХХК | Зөрчилгүй |
| 4 | Цэцэрлэг | | Зөрчилгүй |
| 5 | Иргэдийн төлөөлөгчийн хурал | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Түүвэрт хамрагдсан |
| 6 | Соёлын төв | | Түүвэрт хамрагдсан |
| 7 | Орон нутгийн хөгжлийн сан | | Түүвэрт хамрагдсан |
| 8 | Сум хөгжүүлэх сан | | Түүвэрт хамрагдсан |

*Эх сурвалж: Байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлан*

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн аудитаар тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 57,600.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, хууль хяналтын байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс сумын Засаг даргын Тамгын газар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 636,244.6 мянган төгрөгийн 29 алдаа зөрчил илрүүлснээс 64,748.7 мянган төгрөгийн 20 алдаа зөрчил нь санхүүгийн тайлагналтай холбоотой, 571,495.9 мянган төгрөгийн 9 зөрчил нь Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс гарсан зөрчил байна.

Аудитаар төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд илэрсэн нийт 372,250.6 мянган төгрөгийн 31 алдаа, зөрчлийн 14,377.6 мянган төгрөгийн 9 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 11,140.2 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,419.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгч, 337,313.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 16 зөвлөмжийг хүргүүлжээ.

*Хүснэгт 16. Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн зөрчил** | | | | | | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | 20 | | | 1 | 20 | | | | |
| Засаг даргын Тамгын газар | 4 | 41144.58 | 1 | 1194.58 | | | | | 3 | 39,950.00 |
| Ерөнхий боловсролын сургууль | 7 | 27383.5 | | | 1 | 1,036.50 | 1 | 6378.8 | 5 | 19968.2 |
| Эрүүл мэндийн төв | 4 | 11587.9 | 4 | 11587.9 | | | | | | |
| Цэцэрлэг | 4 | 4064.28 | 3 | 1023.63 | | | 1 | 3040.65 | | |
| Соёлын төв | 1 | 83.74 | | | 1 | 83.74 | | | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 2 | 10571.5 | 1 | 571.5 | 1 | 10000 | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сум хөгжүүлэх сан | 0 | 0 | | | | | | | | |
| **СТА зөрчлийн дүн** | **23** | **94855.5** | **9** | **14377.61** | **4** | **11140.24** | **2** | **9419.45** | **8** | **59918.2** |
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | 5705.7 | | | | | | | 1 | 5705.7 |
| Засаг даргын Тамгын газар | 2 | 19904.6 | | | | | | | 2 | 19,904.60 |
| Ерөнхий боловсролын сургууль | 2 | 148525.8 | | | | | | | 2 | 148,525.80 |
| Эрүүл мэндийн төв | 0 | 0 | | | | | | | | |
| Цэцэрлэг | 1 | 9741.9 | | | | | | | 1 | 9,741.90 |
| Соёлын төв | 1 | 64639.65 | | | | | | | 1 | 64,639.65 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1 | 28877.4 | | | | | | | 1 | 28877.4 |
| Сум хөгжүүлэх сан | 0 | 0 | | | | | | | | |
| **Нийцлийн аудитын дүн** | **8** | **277395.05** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **8** | **277395.05** |
| **Нийт дүн** | **31** | **372250.55** | **9** | **14377.61** | **4** | **11140.24** | **2** | **9419.45** | **16** | **337313.25** |

*Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл*

Харьяа байгууллагуудад илэрсэн алдааны дийлэнх хувийг Шилэн дансны тухай хуулийг бүрэн мөрдөөгүйгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй, орхигдуулсан, төсвийн хэмнэлтийг "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолыг зөрчсөн зөрчил ээлж байна.

*Хүснэгт 17. Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| **Харьяа төсвийн байгууллагуудын дүн** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Алдаа зөрчлийн утга** | **Дүн** | **Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга** | **Буруутай албан тушаалтан** | |
| **Ерөнхий боловсролын сургууль** | | | | | |
| 1 | Тайлант онд 1,749,900 төгрөгийг эм бэлдмэл, тестийг эмчийн жор болон үзлэгийн бүртгэлгүй зарцуулсан. | 1,749.9 | Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 2 | Анхан шатны баримтын дутуу, анхан шатны баримтгүй 12,303,720 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн байна. | 12,303.7 | холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 3 | Нэмэлт санхүүжилт дансанд өөрийн орлогоор 1,040,000 төгрөгийг төвлөрүүлж зөвшөөрөлгүй 1,036,500 төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна. | 1036.5 | Хууль журам зөрчиж зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 4 | Үдийн цайны зардлаас 1,422,770 төгрөг, хоол хүнсний зардлаас 1,635,750 төгрөгийн хүнсний материал нөөц бүрдүүлсэн. | 0 | Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 5 | Тооллогын комисс тусгай зориулалтын материал 1,868,400 төгрөг, бусад үндсэн хөрөнгө 3,000,000 төгрөгийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг тооллогод хамруулсан бүртгэл байхгүй байна. | 4,868.4 | холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж хөрөнгийн тооллогыг чанартай бүрэн хийж гүйцэтгэж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас 78,756.7 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож, 51,716.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. | 130,473.3 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж цаглаварт хугацаанд холбогдох мэдээллийг бүрэн, гүйцэт оруулж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 7 | Тогтмол болон бараа үйлчилгээний бусад зардлаас 1,046,153 төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1,046.2 | холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 8 | Нийгмийн даатгалд 5 албан хаагчийн цалин 10,279.4 мянган төгрөгийн илүү, 8 албан хаагчийн цалинг 3,900.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлж мэдээлж нийгмийн даатгалд 1,524,3 мянган төгрөгийг илүү төлсөн байна. | 6,378.8 | Нийгмийн даатгалд 5 албан хаагчийн цалин 10,279.4 мянган төгрөгийн илүү, 8 албан хаагчийн цалинг 3,900.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн цалинг залруулан мэдээлж төсвөөс төлсөн шимтгэлийн мөнгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх албан шаардлага өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| 9 | Тайлант онд тогтмол зардалд 99,335.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 19,867.0 мянган төгрөг байна. Тус онд 1,814.5 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 18,052.5 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй байна. | 18,052.5 | Дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллах зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Г.Пүрэвцагаан, М.Мягмарсүрэн |
| | **ДҮН** | **175,909.3** | | | |
| **Засаг даргын Тамгын газар** | | | | | |
| 1 | Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшил дансны хуримтлагдсан элэгдэл санхүүгийн тайланд 15,464.9 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 16,659,4 мянган төгрөгөөр буюу 1,194.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна. | 1,194.6 | Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зөрүүг санхүүгийн тайланд тусгуулсан. | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 2 | Тус байгууллагын барилга, байгууламж дансанд бүртгэлтэй 8.472.1 мянган төгрөгийн өртөг бүхий гүний худгийг иргэн Бямбасүрэнд үнэ төлбөргүй ашиглуулж, түрээсийн гэрээ байгуулаагүй байна. | 0 | Сумын төвийн цэвэр усны гүний худгийг ашиглуулах талаар түрээсийн гэрээг байгуулж Орон нутгийн өмчийн газраар баталгаажуулан орлогыг тухай бүх нь байгууллагын дансанд төвлөрүүлэх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 3 | Шилэн дансны цахим сайтад нийт 481,826.1 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 475,106.1 мянган төгрөгийн 135 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14,220.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ болон нийт 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. | 14,220.0 | Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Тус байгууллага нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 58,957.0 мянган төгрөгөөр баталж 52,850.2 мянган төгрөгийг зарцуулж нийт 11,791.4 мянган төгрөг хэмнэхээс санхүүжилтээр 3,705.4 мянган төгрөгийг суутган тооцож, оны эцэст 2401.4 мянган төгрөг буюу төсвийн 10.3 хувийг хэмнэсэн боловч 5,684.6 мянган төгрөгийг хэмнээгүй. | 5,684.6 | Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 5 | Баянхонгор аймгийн ОНСХ-ийн хөрөнгийн эх үүсвэрээр Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газарт БХАОНӨГ/202112023 гэрээний дагуу нийлүүлэгдсэн 26,000.0 мянган төгрөгийн хог тээврийн автомашин,13,950.0 мянган төгрөгийн ачааны автомашиныг хүлээлгэн өгсөн боловч бүртгэлд тусгах талаар шийдвэр гараагүй тул хөрөнгийн бүртгэлд аваагүй байна. | 39,950.0 | Аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлт гаргаж холбогдох шийдвэрийг гаргуулан 39,950.0 мянган төгрөгийн 2 автомашиныг орлого авч, тээврийн хэрэгслийн гэрчилгээг тухайн байгууллагын нэр дээр шилжүүлж авах талаар зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 6 | Аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн “Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай” А/438 дугаартай захирамжаар төсөвт байгууллагуудын нэмэлт орлогыг зарцуулах хувaарийг хавсралтаар батлаагүй байхад дээрх шийдвэрийг үндэслэн Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд үйлчилгээний орлогыг төлөвлөөгүй атлаа байгууллагын үйл ажиллагаагаа явуулан гүйцэтгэлээр 6,387.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансандаа төвлөрүүлж зарцуулсан байна. | 0 | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулж, давсан орлогыг холбогдох шийдвэр гаргуулан Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу зарцуулж алдааг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| | **ДҮН** | **61,049.1** | | | |
| **Иргэдийн төлөөлөгчдийн хурал** | | | | | |
| 1 | Эрдэнэцогт сумын ИТХ-ын Нарийн бичгийн даргын 2021 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” 05 дугаар тушаалаар нягтлан бодогч М.Мягмарсүрэнд цалингийн 40 хувийн урамшуулал 302864 төгрөгийг 7 дугаар сард олгосон бөгөөд албан татварын хөнгөлөлтийг давхар эдэлсэн байна. | 20.0 | ХХОАТ-ын дутуу тооцож авсан татварыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон. | Дарга, нягтлан бодогч | Н.Дэмбэрэл, М.Мягмарсүрэн |
| 2 | Эрдэнэцогт сумын ИТХ нь 2021 онд цахим хуудаст ил тод 78,105.5 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас 72,399.8 мянган төгрөгийн 133 мэдээллийг хугацаандаа байршуулж 5,705.7 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна. | 5,705.7 | Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн. | Дарга, нягтлан бодогч | Н.Дэмбэрэл, М.Мягмарсүрэн |
| | **ДҮН** | **5,725.7** | | | |
| **Эрүүл мэндийн төв** | | | | | |
| 1 | Илүү олгосон цалингийн суутгал 1,024.5 мянган төгрөгөөр цалингийн санг бууруулаагүй, өглөгөөр тусгасан. | 1,024.5 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгалмаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | ЭМГ-аас авсан тендерийн эмийн 1,606.5 мянган төгрөгийн үлдэгдэл эмийн санд үлдэгдлээр байхад нярвын тайлан, НББ-д орлого аваагүй, 187.3 мянган төгрөгийн эм, боох материалыг нярвын тайланд дутуу орлого авсан. | 1,793.9 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгалмаа |
| 3 | Татварын хэлтэст цалингийн санг 26,061.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлснээс ХХОАТ-ын авлагыг санхүүгийн тайланд 633.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан. | 633.1 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгалмаа |
| 4 | Хөрөнгийн дахин үнэлгээ данс Э-тайлангаас 8,136.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. | 8,136.0 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгалмаа |
| | **ДҮН** | **11,587.6** | | | |
| **Цэцэрлэг** | | | | | |
| 1 | Санхүүгийн тайлангийн Эм ороох боох материалын орлого 193.6 мянган төгрөгөөр, зарлага 36.8 мянган төгрөгөөр нярвын тайлангаас зөрүүтэй. | 230.4 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, Ж.Оюунтуяа |
| 2 | Санхүүгийн тайлангийн аж ахуйн материалын орлого нярвын тайлангаас 343.0 мянга, зарлага 368.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн. | 711.9 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, Ж.Оюунтуяа |
| 3 | Санхүүгийн тайлангийн түлш шатахууны орлого нярвын тайлангаас 27.9 мянга, зарлага 53.5 мянган төгрөгөөр зөрүүтэй. | 81.4 | Санхүүгийн тайланд залруулсан. | Дарга, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, Ж.Оюунтуяа |
| 4 | Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэст 3 ажилтны цалингийн санг 2,853.9 мянган төгрөгөөр дутуу, 3 ажилтны цалингийн санг 186.7 мянган төгрөгөөр илүү, нийт цалингийн санг 3,040.6 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн.. | 3,040.6 | Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 3,040.6 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, Ж.Оюунтуяа |
| 5 | Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс нийт 4 төрлийн 9,741.9 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 9,741.9 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгсөн. | Дарга, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, Ж.Оюунтуяа |
| | **ДҮН** | **13,806.2** | | | |
| **Эрдэнэцогт сумын Соёлын төв** | | | | | |
| 1 | Соёлын төвийн эрхлэгчийн "Үр дүнгийн урамшуулал олгох тухай" 2021.07.21-ны өдрийн 12, 2021.10.20-ны өдрийн Б/14, 2021.12.12-ны өдрийн 16 дугаартай тушаалуудын дагуу 7 дугаар сард 350448 төгрөг, 10 дугаар сард 315403 төгрөг, 12 дугаар сард 280358 төгрөг нийт 946209 төгрөгийн 40 хувийн урамшуулалт цалинг нягтлан бодогч Үүрцайхад олгосон байна. Дээрхи цалингаас НДШ 108814 төгрөгийг суутган авч, ХХАОТ-ын 10 хувь болох 83739 төгрөгийг суутган тооцоогүй байна. | 83.7 | Эрдэнэцогт сумын Сангийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Үүрцайхаас урамшуулалт цалингаас суутгаагүй 83,739.00 /Наян гурван мянга долоон зуун гучин есөн/ төгрөгийг суутган авч Баянхонгор аймгийн Бх.Суутган-1 Төрийн сан дахь 100030000901 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон. | Дарга, нягтлан бодогч | Л.Ганчимэг, М.Дүүриймаа |
| | **ДҮН** | **83.7** | | | |
| **Орон нутгийн хөгжлийн сан** | | | | | |
| 1 | Иргэн Б.Цэрэннадмидаас 2021.10.27-ны өдөр өвс тэжээл худалдан авахаар 5715000 төгрөгийг шилжүүлэн сумын | 571.5 | Санхүүгийн тайланд орлого авч залруулсан. | Сумын Засаг дарга, | Д.Цэвэгдорж, М.Дүүриймаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ОНХС-д 16843500 төгрөгийн өвсийг орлого авч ХХОАТ суутгасан дүнгээр 571500 төгрөгийн орлогыг дутуу авсан байна. | | | нягтлан бодогч | |
| 2 | Сумын ИТХ-ын хуралдааны 2020.12.18-ны өдрийн 2/12 дугаар тогтоолоор ОНХС-гийн хөрөнгөөр "Баяр наадмын талбай засвар тохижилт" -ын ажилд 10.0 сая төгрөг батлагдсан байхад сумын Засаг дарга Д.Цэвэгдорж ажил гүйцэтгэх Дугаар БХ-ЭЦ2021/05 гэрээг 2021.12.15-ныөдөр "Эрдэнийн долоон илч" ХХК-тай 20.0 сая төгрөгөөр байгуулсан зөрчил илэрсэн. Тухайн гэрээнд ажлыг 2022.05.15-ны өдөр эхэлж 2022.06.15-ны өдөр дуусгахаар тусгаж, 2021.12.24-ны өдрийн А/193 дугаартай захирамжаар 10.0 сая олгохыг зөвшөөрч мөнгийг урьдчилан төлж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 10,000.0 | Урьдчилж төлсөн 10.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар залруулж бүртгэх. Хууль зөрчиж сумын ИТХ-ын хуралдаанаар баталсан төсөл арга хэмжээний дүнгээс илүү үнээр гэрээ байгуулсан зөрчлийг арилгуулж төлбөрийн 10.0 сая төгрөгийг сумын ОНХС-д буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон. | Сумын Засаг дарга, нягтлан бодогч | Д.Цэвэгдорж, М.Дүүриймаа |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 28877.4 мянган төгрөгийн 5 мэдээллийг хоцроосон. | 28,877.4 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн 6.4.4 дахь заалтыг хуулийн хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, нягтлан бодогч | Д.Цэвэгдорж, М.Дүүриймаа |
| | **ДҮН** | **39,448.9** | | | |
| **Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн** | | **372,250.5** | | | |

*Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл*

## 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй байна. Үүнд:

1. Сумын ЭМТ-д бүртгэлтэй 3,832.5 мянган төгрөгийн мал амьтдын насжилтыг хийгээгүй шалтгааныг байгууллагын нягтлан бодогчоос тодруулахад бүртгэлээр байгаа боловч биетээр байхгүй гэсэн тайлбарыг өгсөн;
2. Байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй оны эхний авлагуудыг барагдуулсан эсэх;
3. Аймгийн Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 26,000.0 мянган төгрөгийн хог тээврийн автомашин, 13,950.0 мянган төгрөгийн ачааны автомашиныг сумын ЗДТГ хөрөнгөдөө шийдвэр гараагүй тул бүртгээгүй байна.Иймд аймгийн ОНХС-ийн 2021 оны санхүүгийн тайланд дээрх хөрөнгийг орлого авах шийдвэр гараагүй байгаа тул сангаас шилжүүлсэн мөнгөн дүнгээр бараа материалын нөөц хөрөнгөөр бүртгэсэн эсэхийг хянаж, аймгийн ТЕЗ-ийн тайланд авч үзэх шаардлагатай байна.
4. Сумын Эрүүл мэндийн төв тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 45,996.5 мянган төгрөгийн авлага, 1,606.5 мянган төгрөгийн өглөг үүссэн ба түүний барагдуулалт, зарцуулалтыг шалгах зэрэг болно.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *1. Тодруулгатай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:* Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" заалтыг хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллагуудын хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг батлаагүй,

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр гаргаагүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:* Төсөв хэлэлцэх батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтын дагуу тухайн жилийн төсвийн хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг баталж, хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу үр дүнг тайлагнаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

### 2. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

*2.1. <u>Илрүүлэлт:</u>* Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, шат шатандаа хууль, тогтоомжийг мөрдөөгүйгээс 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 372,250.5 мянган төгрөгийн 31 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь "Төсвийн ерөнхийлөн захирагч .....өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.... талаар .. бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:* Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж, сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нарын хариуцлагыг сайжруулах.

### 3. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

*<u>3.1 Илрүүлэлт:</u>* Тус сумын төсөвт байгууллагуудад тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийг 13,48.0 мянга, цэцэрлэгийн төсвийг 11,520.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснийг сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос дээрх дүнгээр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх "Засаг дарга ...дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон ... тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ" гэсэн заалтын хэрэгжүүлээгүй байна.

*3.2 <u>Өгсөн зөвлөмж</u>:* Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж сумын ИТХ-д өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж, Төсвийн тухай хуулийн 34.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### 4. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

*<u>4.1 Илрүүлэлт:</u>* Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 141 мэдээллээс 89 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 52 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг тухай бүр нь үнэн зөв мэдээлж байх, түүнд сумын Засаг даргаас тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 05-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Эрдэнэцогт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2022.03.25 | | | БНА-2022/10/СТА-ТТЗ |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | | Эрдэнэцогт сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" заалтыг хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллагуудын хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр гаргаагүй байна. | 0 | Төсөв хэлэлцэх батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтын дагуу тухайн жилийн төсвийн хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг баталж, хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу үр дүнг тайлагнаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Д.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 2 | Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, шат шатандаа хууль, тогтоомжийг мөрдөөгүйгээс 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 372,250.5 мянган төгрөгийн 31 алдаа, зөрчил илэрсэн байна. | 0 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж, сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нарын хариуцлагыг сайжруулах зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Д.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 3 | Тус сумын төсөвт байгууллагуудад тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар 25,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснийг сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос дээрх дүнгээр зөрүүтэй байна. | 0 | Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж сумын ИТХ-д өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж, Төсвийн тухай хуулийн 34.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Д.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 4 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 141 мэдээллээс 89 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 52 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 0 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг тухай бүр нь үнэн зөв мэдээлж байх, түүнд сумын Засаг даргаас тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Д.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн** | | **0** | | | |

---oOo---